



**ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ЗАХИРГАА, ОЮУ ТОЛГОЙ ХХК, МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ**

**ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ УДИРДАХ  
ЖУРАМ**

Гурван талт зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлын 1 дүгээр тогтоолын ХАВСРАЛТ

2020 он

Их булаг

Агуулга

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....

1 дүгээр зүйл. Журмын зорилт .....

2 дугаар зүйл. Хамрах хүрээ .....

3 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт .....

ХОЁРДУГААР БҮЛЭГ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ .....

4 дүгээр зүйл. Гурван талт зөвлөлийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлийг удирдах зарчим

5 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах .....

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ХОРИГЛОЛТ, ХЯЗГААРЛАЛТ .....

6 дугаар зүйл. Мэдээллийг ашиглахтай холбоотой хязгаарлалт .....

7 дугаар зүйл. Зөвлөлийн ажил, үүрэг гүйцэтгэхтэй холбоотой хязгаарлалт

8 дугаар зүйл. Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох .....

9 дүгээр зүйл. Сурталчилгаатай холбоотой хязгаарлалт .....

10 дугаар зүйл. Төлөөлөлтэй холбоотой хязгаарлалт .....

11 дүгээр зүйл. Төлбөр авахтай холбоотой хязгаарлалт .....

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ .....

12 дугаар зүйл. Дотоод хяналтын хорооны эрх, үүрэг .....

13 дугаар зүйл. Журмыг зөрчигчид хүлээлгэх хариуцлага .....

14 дүгээр зүйл. Журмын хүчин төгөлдөр байх хугацаа, нэмэлт өөрчлөлт оруулах

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

### **1 дүгээр зүйл. Журмын зорилт**

1.1 Энэ журмын зорилт нь Гурван талт зөвлөлийн (Зөвлөл) үйл ажиллагааг Ханбогд сумын нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, ил тод байдлыг хангах, олон нийтийн итгэлийг даах нөхцлийг бүрдүүлэх үүднээс:

1.1.1 Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээдийн хувийн ашиг сонирхол болон Зөвлөлийн дүрмийг биелүүлэх зорилгоор гүйцэтгэж буй ажил, үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх,

1.1.2 Зөвлөлийн гишүүд болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээдийн ашиг сонирхлын зөрчлийг удирдах, хянахад оршино.

### **2 дугаар зүйл. Хамрах хүрээ**

2.1. Зөвлөлийн гишүүн, Зөвлөлийн гишүүнийг түр орлож буй гишүүн бус этгээд гишүүнийг түр орлох хугацаанд, Зөвлөлийн хурлаас ажлын хэсэгт томилогдон ажиллаж буй гишүүн бус этгээд Зөвлөл, ажлын хэсгээс даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх үед энэхүү журмыг дагаж мөрдөнө. Энэхүү журмын шаардлагын талаар гишүүн бус этгээдэд урьдчилж танилцуулсан байна.

2.2. Журмын үйлчлэх хүрээ нь журмын үйлчлэлд хамаарах этгээдүүдийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ашиг сонирхлын байдлыг мэдүүлэх болон баталгаажуулах, хувийн ашиг сонирхлын зөрчлийг удирдах, журам зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг зохицуулах үйл ажиллагаанд хамаарна.

### **3 дугаар зүйл. Нэр томъёоны тодорхойлолт**

3.1. “Нийтийн ашиг сонирхол” гэж Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд нь Зөвлөлийн үйл ажиллагаа, дүрмийг хэрэгжүүлэхэд хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар ажиллана гэх олон нийтийн итгэлийг ойлгоно.

3.2. “Хувийн ашиг сонирхол” гэж Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд Зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг ойлгоно.

3.3. “Ашиг сонирхлын зөрчил” гэж Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд Зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх нөхцөл байдлыг ойлгоно.

3.4. “Хамаарал бүхий этгээд” гэж Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээдийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг ойлгоно.

3.5. “Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж Зөвлөлийн гишүүнтэй ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

3.6. “Ашгийн төлөө үйл ажиллагаа” гэж компани, хоршоо, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй зэрэг аж ахуй, худалдаа, зээл, санхүүгийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг ойлгоно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ**

4 дүгээр зүйл. Гурван талт зөвлөлийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлийг удирдах зарчим

4.1. Зөвлөлийн гишүүн нь Зөвлөлийн дүрмийн нэгдүгээр бүлгийн 2 дугаар зүйлийн 2.2-т заасан зарчмуудыг баримталж, хууль дээдлэх зарчимд захирагдан, Зөвлөлийн дүрэмд тусгасан ажил, үүргээ Ханбогд сумын иргэдийн итгэлийг хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, ёс зүйн хэм хэмжээг байнга сахин ажиллана.

4.2. Зөвлөлийн гишүүн нь Зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээнэ.

4.3. Зөвлөлийн гишүүн нь Зөвлөлийн үйл ажиллагаа, өөрийн хариуцсан ажил, үүргийг хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэхгүй бөгөөд Зөвлөлийн дүрэмд заасан албан үүрэгт нь сөргөөр нөлөөлөхүйц аливаа ашиг сонирхлын зөрчил бүхий харилцаанаас ангид байна.

4.4. Зөвлөлийн гишүүн Зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос илүүд үзнэ.

4.5. Зөвлөлийн гишүүн ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлын талаар мэдэгдэх, энэ нөхцөл байдалд Зөвлөлийн ажил, үүргийг гүйцэтгэхээс татгалзах замаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.

4.6. Журмын 2.1-д заасан Зөвлөлийн гишүүн бус этгээд Зөвлөлийн үйл ажиллагаа, ажил, үүргийг хэрэгжүүлэх явцад энэхүү 4 дүгээр зүйлд заасан зарчмуудыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

### **5 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах**

5.1. Зөвлөлийн гишүүн нь Малчдын гомдлыг барагдуулах гэрээнүүдийн дагуу хийхээр тохирсон ажил ба төслүүдийг хэрэгжүүлэх болон Зөвлөлийн дүрэмд заасан аливаа бусад ажилд оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдүүлэг гаргана.

5.2. Зөвлөлийн гишүүн хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэгтэй.

5.3. Зөвлөлийн гишүүн Зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд Зөвлөлийн хурлаас шийдвэрлэж хүлээлгэсэн үүргийг гүйцэтгэхээс татгалзах, энэ тухай өөрийн талын ахлагчаар дамжуулан Удирдах нэгжид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

5.3. Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай Зөвлөлийн гишүүнд мэдээлж болно.

5.4. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл, мэдээлэл хүлээн авсан гишүүн тухайн үүргийг өөр гишүүнээр гүйцэтгүүлэх эсэх саналыг Удирдах нэгжид бичгээр хүргүүлж шийдвэрлүүлнэ.

5.5. Удирдах нэгж тухайн гишүүний гаргасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл, мэдүүлэгт үндэслэн Зөвлөлийн дүрэмд заасны дагуу шийдвэр гаргах бөгөөд ийнхүү шийдвэр гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.

5.6. Зөвлөлийн гишүүн Зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн талын ахлагч, эсхүл Дотоод хяналтын хороонд, холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэж үзвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

5.7. Зөвлөлийн гишүүн Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдуулан аливаа этгээд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдлыг санал болгосон тохиолдолд дараах арга хэмжээг авна:

5.7.1. саналаас татгалзах;

5.7.2. санал тавьсан этгээдийг тодорхойлох, Удирдах нэгж эсхүл Дотоод хяналтын хороонд мэдэгдэх;

5.7.3. тодорхой нөхцөл байдлын улмаас бэлгийг эргүүлэн өгөх боломжгүй бол бэлгийг хадгалах ба энэ тухай өөрийн талын ахлагч, Дотоод хяналтын хороонд нэн даруй мэдэгдэх;

5.7.4. боломжтой бол тухайн үйл явдлын гэрчийг тэмдэглэх;

5.7.5. хуулийн дагуу аливаа хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэж үзсэн зөрчил илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ХОРИГЛОЛТ, ХЯЗГААРЛАЛТ**

6 дугаар зүйл. Мэдээллийг ашиглахтай холбоотой хязгаарлалт

6.1. Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд Зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг Зөвлөлөөс зөвшөөрөөгүй үед задруулах, Зөвлөлийн зорилгоос гадуур, Зөвлөлийн дүрэм, хурлын шийдвэрийн дагуу гүйцэтгэж буй ажил, үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.

#### **7 дугаар зүйл. Зөвлөлийн ажил, үүрэг гүйцэтгэхтэй холбоотой хязгаарлалт**

7.1. Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд Зөвлөлийн дүрэм, хурлын шийдвэрийн дагуу ажил, үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцохыг хориглоно.

7.2. Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш зургаан сарын хугацаанд тухайн этгээдтэй холбоотой шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцохыг хориглоно.

7.3. Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд Зөвлөлийн гишүүнээр сонгогдох, томилогдох, Зөвлөлийн гишүүнийг орлох, Зөвлөлийн шийдвэрээр ажлын хэсэгт томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан эсхүл үргэжлүүлэн гүйцэтгэж байгаа бол Зөвлөлийн гишүүнээр ажиллах, үйл ажиллагаанд нь оролцож байх хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцохыг хориглоно.

#### **8 дугаар зүйл. Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох**

8.1. Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэр гаргахад Зөвлөлийн, эсхүл ажлын хэсгийн гишүүний байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

#### **9 дүгээр зүйл. Сурталчилгаатай холбоотой хязгаарлалт**

9.1. Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд нь улс төрийн зорилготой ухуулга сурталчилгаанд Зөвлөлийн нэр хүнд, эсхүл ажлын хэсгийн гишүүний байдлаа ашиглан оролцохыг хориглоно.

9.2. Монгол Улсын хэмжээнд зохион байгуулж буй ээлжит орон нутгийн сонгуулийн жилд сонгуулийн тов тогтоосон хугацаанаас өмнө нэг сарын хугацаанд Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой иргэдтэй хийх хурал уулзалт, олон нийтийг хамарсан бусад хэлбэрийн үйл ажиллагаа, хэвлэлийн мэдээ болон сурталчилгааны материалыг бэлтгэж олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллээр тараахыг Зөвлөлийн гишүүн болон журмын 2.1-д заасан гишүүн бус этгээдэд хориглоно.

9.3 Зөвлөл нь ээлжит орон нутгийн сонгуулийн тов тогтоосон хугацаанаас өмнө нэг сарын хугацаанд хурал хийхгүй.

### **10 дугаар зүйл. Төлөөлөлтэй холбоотой хязгаарлалт**

10.1. Зөвлөлийн гишүүн, журмын 2.1-д заасан гишүүн бус этгээд дараах тохиолдолд, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын өмнө Зөвлөлийг төлөөлж санал гаргах, шийдвэр гаргах эрхгүй.

10.1.2. өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хүртдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө;

10.1.3. өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захиргааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ**

12 дугаар зүйл. Дотоод хяналтын хорооны эрх, үүрэг (ГТЗ-ын дүрмийн 1.15 заалт)

12.1. Дотоод хяналтын хороо нь Зөвлөлийн гишүүдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийнэ.

12.2. Дотоод хяналтын хороо нь Зөвлөлийн гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, иргэний өргөдөл, гомдолд үндэслэн, эсхүл төлөвлөгөөт хяналт шалгалт явуулж болно.

12.3. Дотоод хяналтын хороо нь ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэгт дүн шинжилгээ хийж, хяналт шалгалтын дүгнэлт гаргаж, Зөвлөлийн хуралд танилцуулах буюу тухайн гишүүний хамаарах талын ахлагчид бичгээр хүргүүлэх, гарсан шийдвэрийг Зөвлөлд танилцуулна.

### **13 дугаар зүйл. Журмыг зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

13.1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг үнэн зөв бөглөөгүй анхны тохиолдолд сануулах, энэхүү зөрчлийг давтан гаргасан тохиолдолд тухайн гишүүнийг эргүүлэн татах саналыг Дотоод хяналтын хорооноос??? түүнийг томилсон, сонгосон талд хүргүүлж шийдвэрлүүлэх.

13.2. Зөвлөлийн гишүүний хувийн ашиг сонирхлын зөрчлийн улмаас Зөвлөлийн үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүжүүлэгч талын зүгээс Зөвлөлийн үйл ажиллагаанд болон Малчдын гомдлыг барагдуулах гэрээний хийхээр тохирсон ажилтай холбоотой төсвийн зардал нэмэгдсэн, хамаарал бүхий этгээд болон нэгдмэл ашиг сонирхолтой этгээдэд давуу байдал үүсгэсэн нь баримтаар нотлогдсон тохиолдолд тухайн гишүүнийг эгүүлэн татах саналыг Дотоод хяналтын хорооноос? түүнийг томилсон, сонгосон талд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

13.3. Зөвлөлийн гишүүний хувийн ашиг сонирхлын зөрчлийн улмаас үүсэн гарсан үр дагавар хуулийн хариуцлага хүлээлгэх хэмжээнд хүрсэн гэж Дотоод хяналтын хорооноос үзсэн тохиолдолд холбогдох эрх бүхий албан тушаалтан, байгууллагад хандана.



13.5. Ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн нь тогтоогдож, тухайн талын ахлагчийн бичгээр үйлдсэн шийдвэрийн дагуу Гишүүнээс хасагдсан этгээдийг Зөвлөлийн гишүүнээр томилогдох, нэр дэвшүүлэх эрхийг хоёр жилийн хугацаанд хориглоно.


**14 дүгээр зүйл. Журмын хүчин төгөлдөр байх хугацаа, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах**

14.1. Энэхүү журам нь 2020 оны 10 сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

14.2. Журмыг Зөвлөлийн хурлаар хүчингүйд тооцсоноос бусад үед журам нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

14.3. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Зөвлөлийн дүрмийн гуравдугаар бүлгийн 1.1, 1.9, 1.12-д заасны дагуу Зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Ханбогд сумыг төлөөлж	Ханбогд сумын Малчдыг	Оюу Толгой ХХК-ийг төлөөлж
Б.Хуяг ..... Ханбогд сумын Засаг даргын орлогч	Х.Нэхийт ..... Баян багийн малчдын төлөөлөл	С.Дорждэрэм ..... Орон нутгийн дэмжлэг, түншлэлийн менежер
Б.Алтангэрэл  ..... Уул уурхай, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	Д.Намсрай  ..... Жавхлант багийн малчдын төлөөлөл	Л.Баярбаатар ..... Орон нутгийн харилцааны менежер
Э.Жамбалсанжид ..... Ханбогд сумын Жавхлант багийн Засаг дарга	Ө.Баттогтох  ..... Жавхлант багийн малчдын төлөөлөл	О.Дарьханд ..... Хэвлэл мэдээллийн ерөнхий зөвлөх
М.Мягмаржав  ..... Ханбогд сумын Баян багийн Засаг дарга	Ч.Намнансүрэн  ..... Жавхлант багийн малчдын төлөөлөл	С.Отгонбаатар ..... Усны менежментийн багийн ахлагч
Д.Эрдэнэцэцэг  ..... Ханбогд сумын Гавилууд багийн Засаг дарга	Р.Бадамдорж  ..... Баян багийн малчдын төлөөлөл	Ж.Эрдэнэбилэг ..... Хөдөлмөрийн харилцааны менежер
	Ц.Ганбаатар  ..... Баян багийн малчдын төлөөлөл	
	Ц.Олонбаяр ..... Номгон багийн малчдын төлөөлөл	
	Д.Эрхэмбаатар  ..... Номгон багийн малчдын төлөөлөл	
	Д.Отгончулуу	



Гавилууд багийн малчдын  
төлөөлөл

У.Гантөмөр




Номгон багийн малчдын төлөөлөл

Т.Насанбуян



Гавилууд багийн малчдын  
төлөөлөл

М.Хашбаатар



Гавилууд багийн малчдын  
төлөөлөл

